

ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

2020-01-22

2019 оны байдлаар тус аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн 100 байгууллагад 985 эрүүл мэндийн ажиллагсад эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн ард шуурхай чанартай хүргэн ажиллаж байна. Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх 5-н жилийн төлөвлөлтийн дагуу мэргэжлийн боловсон хүчний тоог нэмэгдүүлэх, эмч мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагааг орон нутгийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага хамт олонтой хамтран зохион байгуулан ажиллаж ирснээр их эмчийн тоо 227 болж нийт их эмчийн 80,2 хувь нь үндсэн мэргэжил эзэмшснээр хоол боловсруулах замын ургац авах, цөсний суваг боох, улаан хоолойн өргөссөн судас боох, цээжний хөндийн дурангийн мэс засал, уушигны цэврүү авах дурангийн мэс засал зэрэг 30 гаруй хагалгааг орон нутагт амжилттай нэвтрүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн ажиллаж ирсэн.

2019 онд анагаах ухааны их дээд сургууль төгссөн 38 эмнэлгийн мэргэжилтнийг хүлээн авч 94,8 хувийг ажлын байраар ханган сувилагчийн хэрэгцээг хангах үүднээс 14 сувилагчийг орон нутгийн санхүүжилтээр сурган бэлтгэж байна. Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх үүднээс сувилахуйн бакалавр боловсролын сургалтад 22 сувилагчийг хамруулан орон нутгийн 22,1 сая төгрөгийн санхүүжилтээр сургаж байна

“Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгаалал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сум орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж ирсэн 104 хүнд 314.4 сая төгрөг, тэтгэврийн нэг удаагийн тэтгэмж 25 хүнд 456.0 сая төгрөг нийт 129 хүнд 770.0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон. Эрүүл мэндийн салбар байгууллагуудын 314 ажиллагсдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан 650 ажиллагсдыг томуугийн өвчлөлөөс сэргийлэх дархлаажуулалтад хамруулан эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын хувцасаар 116 ажиллагсдыг хангаж 116 ажиллагсдыг хор саармагжуулах нэмэгдэл хүнс тэжээлээр ханган 24,5 сая төгрөг зарцуулсан байна Эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх төгсөлтийн дараах сургалтыг орон нутагт төлөвлөн явуулж 16 удаагийн сургалтад 958 эмч мэргэжилтнийг хамруулан сургаснаар 510 эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг баталгаауулан ажиллаж байна

Төрийн албан хаагчдын нийгмийн асуудалд дэмжлэг тусламж үзүүлэх орон нутгийн хөтөлбөрт 13 эрүүл мэндийн салбарын ажилтан хамрагдаж 40 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлт дэмжлэгт хамрагдсан ба 15 ажиллагсдын орон байрны асуудлыг шийдвэрлүүлэн ажилласан

2020 онд Монгол улсын засгийн газрын 2019 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “ Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгаалал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг өргөн хүрээтэй зохион явуулах зорилтыг тавин ажиллаж байна.

УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТ САНХҮҮГИЙН ХЭЛТЭС